*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

**НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН ТАСГИЙН БАЙЦААГЧ ДЭМБЭРЭЛИЙН ОТГОНТУЯАГИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **I. “БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1.1** Нийгмийн даатгалын багц хууль болон шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах, иргэд, даатгуулагчдыг үнэн зөв мэдээллээр хангах, хууль тогтоомжийг сурталчлах, нийгмийн даатгалын үйлчилгээг хөнгөн шуурхай үзүүлэх. | -Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо<br><br>-Үйлчилгээ үзүүлсэн иргэд даатгуулагчийн тоо | 2024 оны 01 дүгээр сарын 01-ээс хэрэгжиж эхэлж байгаа “Нийгмийн даатгалын багц хууль”-ийн шинэчлэлийн агуулга, хэрэгжүүлэхэд анхаарах асуудал холбогдох зөвлөмжийн талаар Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн BEST хөтөлбөрийн | Өдөр тутмын үйл ажиллагаанда а дүрэм журам, заавар зөвлөмжийг баримтлан, үйлчилгээний заалаар ирж үйлчилгээ авч байгаа 5000-с доошгүй иргэд даатгуулагчда д хуулийн хүрээнд үйлчилгээ үзүүлнэ. | НДЕГ-аас 2025 онд ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна. “Мал аж ахуйн хаваржилтын цаг үеийн байдалтай танилцах ажлын хэсгийн удирдамж”-ийн дагуу Жаргалант сумын Бага хөшөөт, Хүнхэр, Их хөшөөт, Илжгэний эх, Айргийн гозгор, Айргийн өвөр, Улаан сайр зэрэг чиглэлийн малчин 34 өрхөөр орж 39 иргэнд, мөн 2025 оны 09-р сарын 23-ний өдрөөс 2025 оны 09-р сарын 25-ны өдрийг дуустал Говил, Баянцагааны эх, 4-р подьём, Бөхөнгийн өвөр, Энрэл, Дэлэн, Чулуут, Цувраа, Өвөр тэрэгч, | 01-09 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сургалтанд 12 оролцогчидод сургалт орсон. | | Хуурайн ам зэрэг чиглэлийн 23 малчин өрхөөр орж 30 иргэнд Нийгмийн даатгалын шинэчилсэн багц хуулийн талаар,Малчны тэтгэврийн тухай, 0-3 настай хүүхэдтэй эхийн сайн дурын даатгал, малчны сайн дурын даатгалын хөнгөлөлтийн талаарх нийгмийн даатгалын хуулийн мэдэээл, зөвлөгөөг нийт 518 км явж 74 хуудас тараах материал хүргэн ажилаллаа. Утсаар болон биечлэн 3091 иргэнд НД-ын хуулийн зөвлөгөө хүргэсэн. | | |
| 2. | **Арга хэмжээ 1.2.** Нийгмийн даатгальн тухай хууль тогтоомж, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд, программ хангамж, сикосын сайжруулах талаар чиг үүргийн дагуу санал өгөх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах. | Дээд газраас ирсэн аргачлал зааврыг баримтлан 1 удаа боловсруулан ажиллана. | Нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 105 иргэнд нийгмийн даатгалын ач холбогдолын талаар ойлголт өгч шинээр сайн дурын даатгалын гэрээ байгуулан, үүнээс СДД-д 42, малчин 10, 0-3 настай хүүхэдтэй эх 32, ХБХАЭЭ 21-г хамруулан гэрээ болон хувийн хэрэг нээж, шимтгэлийг төлүүлэн программд оруулж авлага хаалт хийж ажилласан. | Дээд газраас ирсэн заавар чиглэлийг баримтлан боловсруулан ажиллана. | Хууль тогтоомж, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд, сикос программтай холбоотой 2 санал утсаар гаргаж, Viber программ, жираад тухай бүр нь программын зөрчил дутагдал алдааг тасгийн даргаар дамжуулан дээд газарт хүргүүлсэн. | 01-09 | 100% |
| 3. | **Арга хэмжээ 1.3.** Нийгмийн даатгалын байгууллагад | | Сикос программтай холбоотой 11 санал хүсэлт утсаар | Ажлын байрны болон үйлчилгээний | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлж буй ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хanган ажиллах. | Шинээр хэрэгжүүлсэн шинэлэг ажлын тоо | холбогдон гаргасан бол Viber программ, Excel хүснэгтээр тухай бүр нь программын зөрчил дутагдал алдааг бичиж дээд газарт хүргүүлсэн. | стандартын хэрэгжилтийг хангах чиглэлээр улирал бүр 1-ээс доошгүй шинэлэг арга хэмжээ санаачлан зохион байгуулж, үр дүнд хүрсэн байна. | Нийгмийн даатгалын тухай хууль, журам заавар, цаг үеийн мэдээ мэдээллийг цаг алдалгүй иргэдэд хүргэх үүднээс газрын фэйж хуудсыг дагахыг иргэдэд уриалан ажилласан мөн Мобиком цахим үйлчилгээний газраар очиж туршлага судласан. | 01-09 | 100% |
| **II. "ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 2.1.** Тэтгэврийн материалын бүрдэл шаардлага бүрэн хангасан эсэх, эрх үүссэн эсэх талаар мэдээлэл, зөвлөгөө өгч, тэтгэвэр бодуулах эрх үүссэн даатгуулагчийн хүсэлтийг хүлээн авч, үндэслэлийг хянан цахим системд бүртгэн, тэтгэврийн байцаагчид шилжүүлэн, шаардлагатай баримт бичгийг программд сканердан оруулна. | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, журмын дагуу хүлээн авсан материалын тоо | Тэтгэврийн материалын бүрдэл шаардлага бүрэн хангасан эсэх, эрх үүссэн эсэх талаар 189 даатгуулагчид мэдээлэл, зөвлөгөө өгч, шинээр тэтгэвэр тогтоолгох 172 иргэний материалыг хүлээн авч шаарлагатай баримт бичгийг программд сканердан оруулж тэтгэврийн байцаагчид шилжүүлсэн. | Иргэд даатгуулагчидийн **320** -аас доошгүй тэтгэврийн материалыг хууль журмын дагуу хүлээн авч программд бүртгэн, сканердаж оруулан ажиллана. | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, заавар журмын дагуу нийт 496 даатгуулагчид мэдээлэл, зөвлөгөө өгч шинээр ӨН-ны тэтгэвэр-165, ТА-ны тэтгэвэр-26, ХЧА-ны тэтгэвэр-42, Цэрэгийн тэтгэвэр-1 ҮОМШӨ тэтгэвэр-2 нийт 236 даатгуулагчын материалыг хүлээн авч бүрэн сканердаж программд оруулан тэтгэврийн байцаагчид шилжүүлсэн байна. | 01-09 | 75% |
| 2. | **Арга хэмжээ 2.2.** Тэтгэвэр авагч банк солих, тэтгэврийн төрөл өөрчлөх, гэр бүлийн гишүүнд 20% нэмж олгох зэрэг бусад тэтгэвэртэй холбоотой ирсэн даатгуулагчийн хүсэлтийг хүлээн авч, | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, журмын дагуу хүлээн | Тэтгэвэр авагч банк солих 103 иргэн, гэр бүлийн гишүүнд 20% нэмж олгох 31 иргэн, бусад тэтгэвэртэй холбоотой 161 хүсэлтийг хүлээн авч үндэслэлийг хянан | Иргэд даатгуулагчийн **240**-с доошгүй хүсэлтийг хүлээн авч хууль журмын дагуу программд | Тэтгэвэр авагч банк солих 150 иргэн, тэтгэврийн төрөл өөрчлөх-33 иргэн , гэр бүлийн гишүүнд 20% нэмж олгох-37 иргэн, бусад тэтгэвэртэй холбоотой ирсэн-98 иргэн нийт 318 даатгуулагчийн хүсэлтийг хүлээн авч, үндэслэлийг хянан хууль журмын дагуу программд бүртгэн, шаардлагатай баримт бичгийг | 01-09 | 132% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үндэслэлийг хянан цахим системд бүртгэн, тэтгэврийн байцаагчид шилжүүлэн, шаардлагатай баримт бичгийг программд сканердан оруулна. | авсан материалын тоо | цахим системд бүртгэн хариуцсан байцаагчид материалыг шилжүүсэн. | бүртгэн, сканердаж оруулан ажиллана. | сканердан оруулж тэтгэврийн байцаагчид шилжүүлсэн. | | |
| 3. | **Арга хэмжээ 2.3.** Ажилгүйдлийн тэтгэмж бодуулахаар ирсэн даатгуулагчийн хүсэлтийг хүлээн авч, үндэслэлийг хянан цахим системд бүртгэн, тэтгэмжийн байцаагчид шилжүүлэн, шаардлагатай баримт бичгийг программд сканердан оруулах. | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, журмын дагуу хүлээн авсан материалын тоо | 106 иргэнд ажилгүйдлийн тэтгэмжтэй холбоотой зөвлөгөө мэдээлэл хүргэж, шинээр 74 ажилгүйдлийн тэтгэмж авахаар ирсэн даатгуулагчийн хүсэлтийг хүлээн авч, үндэслэлийг хянан цахим системд бүртгэн сканердан оруулж тэтгэмжийн байцаагчид шилжүүлэн ажилласан. | Иргэд даатгуулагчийн **240**-с доошгүй хүсэлтийг хүлээн авч хууль журмын дагуу программд бүртгэн, сканердаж оруулан ажиллана. | Ажилгүйдлийн тэтгэмж авахаар утсаар болон биеэр ирж байгаа 388 иргэдэд хуулийн зөвлөгөө өгч, шинээр 91 ажилгүйдлийн тэтгэмж авахаар ирсэн даатгуулагчийн хүсэлтийг хүлээн авч, үндэслэлийг хянан хууль журмын дагуу программд бүртгэн, шаардлагатай баримт бичгийг сканердан оруулж тэтгэмжийн байцаагчид шилжүүлэн ажилласан. | 01-09 | 100% |
| 4. | **Арга хэмжээ 2.4.** Нас барсан даатгуулагчийн ар гэрт олгох тэтгэмжийн баримт материалыг хүлээн авч, бүрдлийг хянан цахим системд сканедан оруулж, тогтоож, хянуулан тэтгэмжийг олгох. | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, журмын дагуу хүлээн авсан материалын тоо | 63 нас барсан даатгуулагчын ар гэрт олгох тэтгэмжийн материалыг хүлээн авч бүрдлийг хянан хууль журмын дагуу программд бүртгэн, шаардлагатай баримт бичгийг сканердан оруулж тэтгэмжийн байцаагчид | НДС-аас олгох тэтгэмжийн тухай хууль, журмын дагуу 90-ээс доошгүй нас барсан даатгуулагчын ар гэрт олгох тэтгэмжийн материалыг программд | НДС-аас олгох тэтгэмжийн тухай хууль, журмын дагуу 90 нас барсан даатгуулагчын ар гэрт олгох тэтгэмжийн материалыг хүлээн авч бүрдлийг хянан хууль журмын дагуу программд бүртгэн, шаардлагатай баримт бичгийг сканердан оруулж тэтгэмжийн байцаагчид шилжүүлэн ажилласан. | 01-09 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шилжүүлэн ажилласан. | бүртгэн, сканердаж оруулан ажиллана. | | | |
| 5. | **Арга хэмжээ 2.5.** Шинээр иргэнтэй сайн дурын гэрээ байгуулан, хувийг хэрэг нээж, шимтгэлийг төлүүлэх, авлага үүсгэсэн бол гэрээнд заасны дагуу /гэрээний хүчинтэй хугацаанд/ шимтгэл алдангийг төлүүлэх, шаарлагатай баримт бичгийг хүлээн авч программд сканердан оруулах. СДД-д илүү төлсөн, давхардсан шимтгэл буцаах өргөдөл хүлээн авч СДД байцаагчид шилжүүлэх. | Сайн дурын даатгалын санд шимтгэл төлсөн даатгуулагчын гэрээний бүрдлийг хянан хууль журмын дагуу хүлээн авсан, зөвлөгөө мэдээлэл өгсөн иргэдийн тоо | Сайн дурын даатгалын гэрээтэй 209 даатгуулагчийн гэрээг сунгаж, шимтгэл төлсөн 105 иргэнд шинээр сайн дурын даатгалын гэрээ байгуулан, хувийн хэрэг нээж, гэрээнд заасны дагуу /гэрээний хүчинтэй хугацаанд/ шимтгэлээ төлөөгүй 153 иргэнд хугацаа хэтэрсэн хоногийн алдангийг тооцож нөхөн төлүүлж, шаарлагатай баримт бичгийг хүлээн авч программд оруулан авлага хаалт хийж ажилласан. | СДД-н шимтгэл төлсөн 260-аас доошгүй иргэнтэй шинээр сайн дурын даатгалын гэрээ байгуулан хувийн хэрэг нээж, авлага үүсгэсэн бол гэрээнд заасны дагуу /гэрээний хүчинтэй хугацаанд/ шимтгэл алдангийг төлүүлнэ | Сайн дурын даатгалын гэрээтэй 103 даатгуулагчийн гэрээг сунгаж, СДД-н шимтгэл төлсөн 267 иргэнд шинээр сайн дурын даатгалын гэрээ байгуулан, хувийн хэрэг нээж, гэрээнд заасны дагуу /гэрээний хүчинтэй хугацаанд/ шимтгэлээ төлөөгүй 185 иргэнд хугацаа хэтэрсэн хоногийн алдангийг тооцож нөхөн төлүүлж, шаарлагатай баримт бичгийг хүлээн авч программд оруулан авлага хаалт хийж ажилласан. | 01-09 | 100% |
| 6. | **Арга хэмжээ 2.6.** Эмнэлгийн байгууллагаас ирүүлсэн хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн эмнэлгийн хуудас иргэний хүсэлтийн дагуу цахим системд бүртгэнэ. | Холбогдох журам зааврын дагуу программд бүртгэсэн тоо | Эмнэлгийн байгууллагаас ирүүлсэн ХЧТА-ны 243, ЖА-ны 171, тэтгэмжийн эмнэлгийн хуудсыг иргэний хүсэлтийн дагуу цахим системд бүртгэн баталгаажуулж, 213 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсөн байна. | Эмнэлгийн байгууллагаас ирүүлсэн ХЧТА, ЖА тэтгэмжийн эмнэлгийн хуудас иргэний хүсэлтийн дагуу цахим системд бүртгэх. | Эмнэлгийн байгууллагаас ирүүлсэн ХЧТА-ны 27, ЖА-ны 44, тэтгэмжийн эмнэлгийн хуудсыг иргэний хүсэлтийн дагуу цахим системд бүртгэн баталгаажуулж, 51 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсөн байна. | 01-09 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7. | **Арга хэмжээ 2.7.** Рашаан сувилалын зардал протез, ортопедын төлбөрийн баримт материалыг хүлээн авч, бүрдлийг хянан цахим системд сканердан оруулж, тэтгэмжийн байцаагчид шилжүүлэх. | Холбогдох журам зааврын дагуу программд бүртгэсэн тоо | ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр авдаг 4 иргэний рашаан сувилал ор хоног болон замын зардлын баримтыг хүлээн авч тэтгэмжийн байцаагчид шилжүүлж ажилласан. | Рашаан сувилалын зардал протез, ортопедын төлбөрийн баримт материалыг хүлээн авч тэтгэмжийн байцаагчид шилжүүлэх | ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр авдаг 2 иргэний рашаан сувилал ор хоног болон замын зардлын баримтыг хүлээн авч тэтгэмжийн байцаагчид шилжүүлж ажилласан. | 01-09 | 100% |
| 8 | **Арга хэмжээ 2.8.** Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүссэн эсэх талаар мөн элчин сайдын яаманд албан бичиг болон тодорхойлолтыг холбогдох газруудад маягтын дагуу гаргаж өгөх. | Холбогдох журам зааврын дагуу программд бүртгэсэн тоо | Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүссэн 52,эрх үүсээгүй 98 нийт иргэнд тодорхойлолт гарган мөн элчин сайдын яаманд албан бичиг болон тодорхойлолтыг холбогдох газруудад маягтын дагуу 85 иргэнд гаргаж өгсөн. | Маягтын дагуу 20-оос доошгүй иргэнд гаргаж өгнө. | Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүссэн эсэх талаар хөдөлмөр халамжийн газарт , мөн элчин сайдын яаманд албан бичиг болон тодорхойлолтыг холбогдох газруудад маягтын дагуу 14 иргэнд гаргаж өгсөн. | 01-09 | 65% |
| 9 | **Арга хэмжээ 2.9.** Эрүүл мэндийн албан журмын даатгалд хамрагдахаар ирсэн иргэдэд хэрхэн шимтгэл төлөх талаар зөвлөн туслах. | Холбогдох журам зааврын дагуу программд бүртгэсэн тоо | Эрүүл мэндийн албан журмын даатгалд хамрагдахаар ирсэн 151 иргэнд “И-Баримт” аппликейшн-аар хэрхэн шимтгэлээ төлөх талаар зөвлөн тусалж ажилласан. | И-Монголиа, И-Баримт аппликейшн-аар хэрхэн төлбөр төлөх талаар зааж өгөх. | Эрүүл мэндийн албан журмын даатгалд хамрагдахаар ирсэн 154 иргэнд “И-Баримт”, И-Монголиа аппликейшн-аар хэрхэн шимтгэлээ төлөх талаар зөвлөн тусалж ажилласан. | 01-09 | 100% |
| 10 | **Арга хэмжээ 2.10.** Архивын лавлагааны хүсэлтийг хүлээн авч | | Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн QR кодтой лавлагааг 215 | 150 -аас доошгүй архивын | Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн QR кодтой лавлагааг 286 иргэнд гаргаж өгч 2000 оноос өмнөх | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үндэслэлийг хянан цахим системд бүртгэн, архивын ажилтанд шилжүүлэх, QR кодтой лавлагааг иргэдэд ажилласан хугацаагаар гаргаж өгөх. 2000 оноос өмнөх хугацааны шимтгэл төлөлтийн лавлагааны өргөдлийг хүлээн авч архивын байцаагчид шилжүүлэх. | Хүсэлтийн тоо | иргэнд гаргаж өгч ажилласан | лавлагааны хүсэлтийг хүлээн авч үндэслэлийг хянан архивын ажилтанд шилжүүлэх, QR кодтой лавлагааг 230 иргэдэд ажилласан хугацаагаар гаргаж өгөх. | хугацааны шимтгэл төлөлтийн 136 лавлагааны өргөдлийг хүлээн авч архивын байцаагчид шилжүүлэн ажилласан. | 01-09 | 90% |
| **III.“ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 3.1.<br>- Нийгмийн даатгалын байгууллагын бүтээмжийг нэмэгдүүлэх, соёлыг төлөвшүүлэх, менежментийн чадавхийг бэхжүүлэх зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй “ISO 37001:2016, ISO 9001:2015 стандартын нэгдсэн менежментийн тогтолцоо”-г үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж, тасралтгүй сайжруулалт хөгжүүлэлтийг тогтмол хийж санаачлагатай ажиллах | -Стандартыг мөрдөж ажилласан тухай ажлын тайлан, гүйцэтгэл<br>-Санаачлан хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, чанар | Төрийн байгууллагын бүтээмжийг нэмэгдүүлэх, соёлыг төлөвшүүлэх, менежментийн чадавхийг бэхжүүлэх, иргэд, даатгуулагчийг нийгмийн хамгаалалын аливаа эрсдлээс хамгаалах, зэрэгт төрийн албан хаагчийн ёс зүйг баримтлан авилга, ашиг сонирхолын зөрчилгүй ажиллаж, нийгмийн даатгалын үйлчилгээний чанартай, хүртээмжтэй, шуурхай, нээлттэй, ил тод байдлыг хангаж, “Нэгдсэн менежментийн тогтолцоо”-г хэрэгжүүлэх үйл ажиллагаанд идэвх санаачлагатай оролцож 2024 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө батлуулж төлөвлөгөөний дагуу ажлаа гүйцэтгэж байна. | Төлөвлөгөөний дагуу үр дүнтэй санаачлагатай ажиллах. | -Төрийн албан хаагчийн ёс зүйг баримтлан авлига,ашиг сонирхлын зөрчилгүй ажиллаж, нийгмийн даатгалын үйлчилгээний чанартай, хүртээмжтэй, шуурхай, нээлттэй, ил тод байдлыг хангаж, “Нэгдсэн менежментийн тогтолцоо”-г хэрэгжүүлэх үйл ажиллагаанд идвэх санаачилагатай оролцож ажилласан.<br>- Өмч хамгаалах ажил хүлээлцэх байнгын зөвлөлд ажиллаж 2 удаагийн хурлаар төлөвлөгөө баталж НДЕГ-т актлах хөрөнгийн жагсаалт гаргаж явуулсан. Мөн үндсэн хөрөнгийн тооллого хийж байцаагч ажилчдын хөрөнгийн картыг шинэчлэн бүртгэсэн. | 01-09 | 100% |
| 2 | Арга хэмжээ 3.2. | Санаачлан хэрэгжүүлсэн арга | “Нийгмийн даатгалын хамрагдалтыг | Төлөвлөгөөний дагуу үр дүнтэй | - Ажилгүйдлийн тэтгэмж шинээр тогтоолгосон даатгуулагчид руу утсаар | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | “Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын өр барагдуулах нэрэмжит жил”-ийн ажлын хүрээнд хуваарь, төлөвлөгөөний дагуу нийгмийн даатгалын сайн дурын даатгалыг сурталчлан таниулж сайн дураар даатгуулах ажлуудыг хийж гүйцэтгэх. | хэмжээний тоо, ажлын гүйцэтгэлийн хувь | нэмэгдүүлэх” 2024 оны нэрэмжит жилийн хүрээнд СДД-21, ААН-13 хамруулж ажилласан. | санаачлагатай ажиллах Ажилгүйдлийн тэтгэмж шинээр тогтоолгосон даатгуулагчид тай утсаар холбогдож 10 иргэнийг СДД хамруулах. | холбогдон 10 иргэнийг СДД даатгалд хамруулсан.<br>- Байгууллагаас зохион байгуулсан сургалт зохион байгуулах, нээлттэй хаалганы өдөрлөг тус бүрд идэвхтэй оролцож үйлчилгээний хэсгээс үйлчлүүлж байгаа иргэдэд нийгмийн даатгалын сайн дурын даатгалын ач холбогдлыг таниулан сурталчилж шинээр 76 даатгуулагч хамруулсан. | 01-09 | 100% |
| 3 | <u>Арга хэмжээ 3.3.</u><br>Гадаад, дотоод орчинд чиглэсэн сургалт сурталчилгааг хийх | Сургалт, сурталчилгаа мэдээлэл хийсэн тоо<br>Хамрагдсан албан хаагчийн тоо<br>Сургалтын тайлан | 2024 оны 01 дүгээр сарын 01-ээс хэрэгжиж эхэлж байгаа Нийгмийн даатгалын багц хуулийн талаар Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн BEST хөтөлбөрийн сургалтанд 12 оролцогчид сургалт орсон. | Хуваарийн дагуу 2 удаа шууд бичлэгт оролцох, улирал бүр пост постер, контентын шинэ санал санаачилга гаргана. | 2024 оны 01 дүгээр сарын 01-ээс хэрэгжиж эхэлж байгаа Нийгмийн даатгалын багц хуулийн талаар сургалт сурталчилгаа хариуцсан байцаагч Д.Хөвсгөлтэй Орхон аймгийн Мал эмнэлэгийн газарт сургалт орж мэдээлэл хүргэсэн. | 01-09 | 100% |
| 4 | <u>Арга хэмжээ 3.4.</u><br>Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах, баримт бичгийг стандартын дагуу боловсруулах, архивын материалыг хуваарьт заасан хугацаанд архивт бүрэн хүлээлгэн өгөх. | Баримт бичгийг стандартын дагуу боловсруулж үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан эсэх<br><br>Архивын баримтыг хугацаанд нь өгсөн байдал<br><br>Хүлээлгэн өгсөн баримтын тоо, гүйцэтгэлийн чанар | 2023 оны өөрийн хувиарлаж авсан ААНБ-ын 6 боть баримт, СДД-ын 2022 он, 0-3 настай хүүхдээ харж байгаа СДД-н 2020-2022 оны гэрээг үдэж архивд хүлээлгэн өгсөн. | Батлагдсан хуваарийн дагуу өмнөх оны баримтыг эхний улиралд багтаан бүрэн архивт хүлээлгэн өгч, баримт бичгийн стандартын дагуу боловсруулах | 2024 оны сайн дурын даатгалын хуваарилж авсан 6 боть баримтыг журмын дагуу архивын баримт болгон үдэж архивд хүлээлгэн өгсөн. | 01-09 | 100% |
| | <u>Арга хэмжээ 3.5</u><br>Төрийн албаны тухай хуулийн 37, 39 дүгээр зүйл, Авлигын эсрэг хуулийн 7,8 дугаар зүйл, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай | Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль болон төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд | | - Авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, холбогдох хууль | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хуулийн 7, 8 дугаар зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн Гуравдугаар бүлэгт заасан хориглолт, хязгаарлалт, Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэмжээ” гэх мэт хууль дүрэм журмыг мөрдлөг болгон ажиллаж аливаа хууль бус үйлдэл, зөрчил, авилга, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээллийг нэн даруй холбогдох байгууллага албан тушаалтанд мэдээллэх. | мөрдөгдөх бусад хууль, журам, тогтоол хэм хэмжээг мөрдөж ажилласан байдал<br><br>Холбогдох сургалтуудад хамрагдсан тоо | 2024 онд Авилга ашиг сонирхлын болон Ёс зүйн зөрчилгүй ажилласан. | тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ёс зүйн зөрчилгүй ажиллах<br>-Хууль бус үйлдэл, зөрчлийн талаарх мэдээллийг мэдсэн даруй холбогдох албан тушаалтанд мэдээллэж ажиллах | Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Авилга ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь”, Ёс зүйн хорооноос зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэглээ” сэдэвт сургалтанд цахимаар тус тус хамрагдаж мэдлэгээ дээшлүүлж хууль дүрэм журмыг мөрдлөг болгон ажиллаж ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд байгууллагын ЭБЭТ-д мэдүүлж ажилласан.<br>Авлига ашиг сонирхлын болон Ёс зүйн зөрчилгүй ажилласан. | 01-09 | 100% |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа сараар | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | <u>Арга хэмжээ 1</u><br>Хамт олноороо байгууллагын гадаа 50м хүртэлх газрын хог, цас цэвэрлэх | Орчин цэвэрхэн байх | 3 удаа | Орчин цэвэр байх | Байгууллагын орчин цэвэрхэн болсон. /4 удаа/ | 01-09 | 100% |
| 2. | <u>Арга хэмжээ 2</u><br>“Тэр бум мод” үндэсний хөөдөлгөөн Орхон аймгийн Ногоон эрдэнэт хөтөлбөрийн хүрээнд байгууллагаараа 3 замын уулзварт 180 мод, Сархиа ууланд мод тус тус тарьсан. | Стандартын дагуу | 1 удаа | Ногоон байгууламж нэмэгдэх | Ногоон байгууламж нэмэгдэн, орчны тохижилт сайжирсан. | 01-09 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | Арга хэмжээ 3<br>Засаг даргын захирамжийн дагуу төрийн байгууллагын цасны баярт оролцсон | Удирдамжийн дагуу | 1 удаа | Эрүүл агаарт олон төрөлт тэмцээн уралдаанд орсон | Цасны баярт хамт олны төлөөлөлтэй очиж тэмцээнд амжилттай оролцсон. | 01-09 | 100% |
| 4. | Арга хэмжээ 4<br>Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулсан “Жаргалтай үрс” баярын арга хэмжээнд 2 хүүхэдтэйгээ оролцсон. | Удирдамжийн дагуу | 1 удаа | Гэр бүлтэйгээ 1 өдрийг хөгжилтэй өнгөрөөх | Хоёр хүүхдээ баярлуулж кино үзүүлж, тоглоомын төвд тоглуулж өдрийг хөгжилтэй өнгөрүүлсэн. | 01-09 | 100% |
| 5. | Арга хэмжээ 5<br>ЗДТГ-с зохион байгуулсан Төрийн албан хаагчдын сургалтад сууж ур чадвар дээшлүүлэх | Сургалтад хамрагдсан тоо, Шалгалтын оноо | ЗДТГ-с зохион байгуулсан Төрийн албан хаагчдын сургалтад сууж ур чадвар дээшлүүлэх | Мэдлэгээ дээшлүүлсэн байна. | “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, хэрэгжилт, сэтгэлгээний өөрчлөлт” сургалтад сууж сертифекат авсан. | 01-09 | 100% |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1. Монгол бичгээр унших, бичих чадвараа дээшлүүлэх | Сургалтад хамрагдсан тоо, Шалгалтын оноо | НДЕГ-аас зохион байгуулж буй Үндэсний бичгийн сургалт, Насан туршийн боловсролын төвийн багшийн сургалтад хамрагдаж мэдлэгээ дээшлүүлсэн | Мэдлэгээ дээшлүүлсэн байна. | Удирдлагын академийн монгол бичгийн хичээлд хамрагдан Дунд шатны сертифекат авсан. | 01-09 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | Арга хэмжээ 2. PowerPoint дунд шатны сургалтанд суух ур чадвар дээшлүүлэх | Сургалтад хамрагдсан тоо | - | Мэдлэгээ дээшлүүлсэн байна. | Зангиа Академийн PowerPoint дунд шатны сургалтад суралцаж байна. | 01-09 | 100% |
| 3. | Арга хэмжээ 3. “Мэдээллийн аюулгүй байдал” сургалтанд хамрагдах | Сургалтад хамрагдсан тоо,<br><br>Шалгалтын оноо | - | Мэдлэгээ дээшлүүлсэн байна. | Тагнуулын ерөнхий газрын Орхон аймагдах салбарын Байгууллагын удирдлага, нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтны сургалтад суусан. Удирдлагын академийн “Төрийн албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад 2025.12.08 наас хамрагдаад явж байна | 01-09 | 100% |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН ТАСГИЙН БАЙЦААГЧ ................................. / Д.ОТГОНТУЯА / 2025–12-15